



31

ӨМНӨГОВЬ АЙМАГ
ГУРВАНТЭС СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

20 19 оны 01 сарын 17 өдөр

Дугаар 01

Урт


Ажлын төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дахь заалтыг үндэслэн Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2019 оны ажлын төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2. Төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллахыг Хурлын дарга /Б.Отгонбаяр/, Тэргүүлэгчид, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /П.Одончимэг/ нарт үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ОТГОНБАЯР

463190001

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн
2019 оны 10 дугаар тоот тогтоолын хавсралт



**ГУРВАНТЭС СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
2019 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хийгдэх ажлууд	Нэг. Удирдлага зохион байгуулалтын талаар												Хариуцах эзэн		
		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12			
1	ИТХурлын үзэл баримтлал, Засаг даргын Үндсэн чиглэл, мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар арга хэмжээ авч хэрэгжилт, үр дүнг нь иргэдэд байнга мэдээлэх, үнэлэлт дүгнэлт өгөх															ИТХ-ын дарга, Тэргүүлэгчид, Төлөөлөгчид
2	ИТХурлын хороодын ажлын төлөвлөгөөг баталж, удирдлага, зохион байгуулалтаар хангах, үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлэх															ИТХ-ын хороод
3	Сумын ИТХ-ын төлөөлөгчдийг сонгогдсон тойрогт нь ажиллуулах, багийн хурал, мал тооллого болон нэгдсэн арга хэмжээнүүдэд оролцуулж хийсэн ажлын үр дүнг тооцож ажиллах															ИТХ-ын дарга, ИТХТ-ийн нарийн бичгийн дарга
4	Төрийн үйлчилгээг иргэдэд хөнгөн шуурхай хүргэх, хармуцлагын тогтолцоог сайжруулахад анхаарч, байгууллага, мэргэжилтнүүдийн тайланг хэлэлцэж зөвлөмж өгөх /төлөвлөгөө гаргах/															ИТХ-ын дарга, Тэргүүлэгчид
5	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн ажлыг эрчимжүүлж, иргэдэд хууль сурталчлах															ГХУСАЗСЗөвлөл
6	Сумын Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг аймгийн болон Төрийн дээд шагналд тодорхойлох															ИТХ-ын дарга, ИТХТ-ийн нарийн бичгийн дарга
7	БИНХурлын дарга нарын ажлын хармуцлагыг сайжруулах, удирдлага зохион байгуулалтаар хангах, гэрээ байгуулах, ажлын үр дүнг тооцож ажиллах															ИТХТ-ийн нарийн бичгийн дарга
8	Сум орон нутгийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан иргэн, аж ахуйн нэгжийг ИТХурлын нэрэмжит шагналаар шагнаана.															ИТХ-ын дарга, Тэргүүлэгчид
10	Улаан загалмайн ажлыг иргэдэд сурталчлах, сайн үйлсийн аян зохион байгуулах, улаан загалмайн татварыг төвлөрүүлэх															ИТХ-ын дарга, ИТХТ-ийн нарийн бичгийн дарга

11	Үйл ажиллагаандаа иргэдийн санал бодлыг тусгах, тэдний тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх зорилгоор сар бүрийн тогтмол өдөрт иргэдийг хүлээн авч уулзах "Өглөөний цай" уулзалтыг зохион байгуулж хэвших/ Хуваарь гаргаж, хуваарийн дагуу хүлээж авах/																			ИТХ-ын дарга
12	Хэлмэгдсэдийн дурсгалыг хүндэтгэх өдрийг тохиолдуулан арга хэмжээ зохион байгуулах																			ИТХ-ын дарга, ИТХТ-ийн нарийн бичгийн дарга
13	"Төлөөлөгчийн нэг өдөр" арга хэмжээг зохион байгуулах																			ИТХ-ын төлөөлөгчид, ажлын алба
14	ИТХ-ын ажлын албаны туршлага солилцох нэгдсэн арга хэмжээнд оролцох																			ИТХ-ын ажлын алба

Хоёр. Нийгмийн бодлогын хүрээнд

1	Иргэд аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн саналд тулгуурлан орон нутагт шаардлагатай дүрэм, журам боловсруулж батлан мөрдөж хэрэгжилтэнд хяналт тавина																			ИТХ-ын дарга, Тэргүүлэгчид, Төлөөлөгчид, Нийгмийн бодлого, хууль эрх зүйн хороо
2	Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас гарсан шийдвэрийг сурталчлах, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих																			ИТХ-ын дарга, Тэргүүлэгчид, Төлөөлөгчид, Нийгмийн бодлого, хууль эрх зүйн хороо
3	Төрийн үйлчилгээний байгууллагууд ард иргэдэд үйлчилж буй байдалд хяналт тавих																			ИТХ-ын дарга, Тэргүүлэгчид, Төлөөлөгчид, Нийгмийн бодлого, хууль эрх зүйн хороо
4	Сумын Засаг даргын үйл жилийн хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавих, үнэлэлт дүгнэлт өгөх																			ИТХ-ын дарга, Тэргүүлэгчид, Төлөөлөгчид, Нийгмийн бодлого, хууль эрх зүйн хороо
5	Иргэд, хүүхэд залуучуудын амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах																			ИТХ-ын дарга,
6	Амьжиргааг дэмжих зөвлөлийн ажилд хяналт тавих																			ИТХ-ын дарга, Тэргүүлэгчид, Төлөөлөгчид, Нийгмийн бодлого, хууль эрх зүйн хороо
7	2019 оныг "Хөдөө аж ахуй, үйлдвэржилтийн жил" болгон зарласантай холбогдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэдээллийг сонсож хэлэлцэх, санал дүгнэлт өгөх																			ИТХ-ын тэргүүлэгч
8	Яруу найргийн тэмцээн зохион байгуулах																			ИТХ-ийн ажлын алба
9	Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, албан газрууд ажилтнуудаа хууль эрх зүйн мэдээлэл өгөх, хуулийн сан бүрдүүлэх, ард иргэдийн хууль зүйн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр хийж байгаа үйл ажиллагаанд хяналт тавих																			ИТХ-ын дарга, Тэргүүлэгчид, Төлөөлөгчид, Нийгмийн бодлого, хууль эрх зүйн хороо

10	Төрийн байгууллага, эрх бүхий албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн байдалд хяналт тавих																			ИТХ-ын дарга, Тэргүүлэгчид, Төлөөлөгчид, Нийгмийн бодлого, хууль эрх зүйн хороо
11	Тусламж дэмжлэг шаардлагатай иргэдийн асуудлыг шийдвэрлэхэд анхаарч ажиллах																			ИТХ-ын дарга
12	Ахлах ангийн сурагчдын дунд "Ижийдээ захидал бичээрэй" уралдаан зохион байгуулах, дүгнэх																			ИТХ-ын ажлын алба
13	Аж ахуйн нэгж, албан байгууллагын албан хаагчид болон иргэдийн дунд илтгэлийн уралдаан зарлах																			
14	Сум орон нутагт тулгамдаж буй асуудлаар ахлах ангийн сурагчдын дунд "Мини парламент" арга хэмжээг зохион байгуулах																			ИТХ-ын ажлын алба
15	Алдарт эх одонтой эхчүүдийн зөвлөгөөн зохион байгуулах																			ИТХ-ын ажлын алба, ЗДТГ
16	Дархан бэр алдаршуулах арга хэмжээг зохион байгуулах																			ИТХ-ын ажлын алба, ЗДТГ
17	Ерөнхий боловсролын сурагчдын дунд 10 төрлийн хичээлээр массын олимпиад зохион байгуулах																			ИТХ, ЗДТГ, ЕБС
18	Сэтгэлийн бэлэг арга хэмжээг зохион байгуулах																			ИТХ-ын төлөөлөгчид, ажлын алба

Гурав. Сургалт, Сурталчилгааны талаар.

1.	Хууль сурталчлах зорилгоор хуулиудын заалтаар анхааруулга, санамж, зөвлөмж хийж иргэдэд сурталчлах																			ИТХ-ын дарга, Тэргүүлэгчид, Төлөөлөгчид, БИНХ-ын дарга нар
2.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор албан байгууллага, иргэдийн дунд хууль сурталчлах "Иргэн ба хууль" арга хэмжээг зохион байгуулах /тусгай хөтөлбөрөөр/																			ИТХ-ын дарга, ИТХТ-ийн нарийн бичгийн дарга, Нийгмийн бодлого, хууль эрх зүйн хороо
3.	Иргэний танхимын үйл ажиллагааг тогтмолжуулж, хэлэлцүүлгүүдийг зохион байгуулах																			ИТХ-ын дарга, Тэргүүлэгчид, ИТХТ-ийн нарийн бичгийн дарга, хурлын хороод
4.	Архидан согтуурах, мансуурах, донтолтоос урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавин ажиллах																			ИТХ-ын дарга, ИТХТ-ийн нарийн бичгийн дарга, Нийгмийн бодлого, хууль эрх зүйн хороо
5.	УИХ-ын даргын ивээл дор жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг сумын Шатрын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах																			ИТХ-ын ажлын алба



36

**ӨМНӨГОВЬ АЙМАГ
ГУРВАНТЭС СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

20 19 оны 01 сарын 17 өдөр

Дугаар 02

Урт


**Ажилчдын орон тоо, цалингийн сан
тогтоох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь заалтыг үндэслэн Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажилчдын орон тоо, цалингийн санг нэгдүгээр, Багийн Иргэдийн Нийтийн Хурлын дарга нарт сар бүр олгох урамшууллыг хоёрдугаар, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд улиралд олгох урамшууллыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Уг тогтоолд заагдсан ажилчдын Үндсэн цалин, нэмэгдэл урамшууллыг тухай бүр тооцож олгохыг Нягтлан бодогч /Н.Цэнгэлмаа/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ОТГОНБАЯР

463190003



Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн
 2019 оны ... тоот тогтоолын нэгдүгээр хавсралт

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын орон тоо, цалингийн сан

№	Албан тушаал	Цалингийн шатлал	Үндсэн цалин	Ажилласан жил			Нэмэгдлүүд					Дүн	
				Улсад	Төрийн байгууллагад	Тухайн албан тушаалд	Онцгой нэмэгдэл /% /	ТАХ-ны /% /	Зэрэг дэв /% /	ХАСХОМ /% /	Үр чадвар		
1	ИТХ-ын дарга	УТ	835276	15	15	3	/30/ 250582						1085858
2	ИТХТ-ийн нарийн бичгийн дарга	ТЗ-7-4	754699	14	14	14		/10/ 75469	/22/ 166033	/10/ 75469			1071670
3	ИТХ-ын жолооч, ажилтан	ТҮ-3-1	434240	-	-	-	-	-	-	-	-	/30/ 130272	560512

12



38


Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн
2019 оны 02 тоот тогтоолын хоёрдугаар хавсралт

Багийн Иргэдийн Нийтийн хурлын дарга нарын урамшуулал

№	БИНХ-ын дарга	Олгох урамшуулал /сар бүр/	Тайлбар
1	Гоёот багийн ИНХ-ын дарга	166082	ЗЗНДНТУТХ-ийн 38 дугаар зүйлийн 38.6 дахь хэсэгт зааснаар
2	Баясах багийн ИНХ-ын дарга	166082	
3	Тост багийн ИНХ-ын дарга	166082	
4	Урт багийн ИНХ-ын дарга	166082	
5	Бага-Овоо багийн ИНХ-ын дарга	166082	
ДҮН		830410	

39

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн
2019 оны... тоот тогтоолын гуравдугаар хавсралт



ИТХТэргүүлэгчдийн урамшуулал

№	БИНХ-ын дарга	Олгох урамшуулал /Улиралд нэг удаа/	Тайлбар
1	О.Батмөнх	192000	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010.08.20-ны өдрийн 94 тоот тогтоолоор
2	Г.Гангамаа	192000	
3	Ц.Манлайбаатар	192000	
4	Ж.Мөнхбаяр	192000	
5	Л.Пүрэвдорж	192000	
6	Н.Эрхэмбаяр	192000	
ДҮН		1152000	



410

**ӨМНӨГОВЬ АЙМАГ
ГУРВАНТЭС СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2019 оны 01 сарын 17 өдөр

Дугаар 03

Урт

Сум хөгжүүлэх сангийн зөвлөл
шинэчлэн батлах тухай

Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журмын 3.3.3 дахь заалтыг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сум хөгжүүлэх сангийн орон тооны бус зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Зөвлөлийн дарга: О.Баттогтох-Сумын Засаг дарга

Гишүүдэд:
П.Болд-эрдэнэ -Гоёот багийн төлөөлөл
Ж.Пунцагбал - Баясах багийн төлөөлөл
Д.Алимаа - Тост багийн төлөөлөл
Д.Бат-очир - Урт багийн төлөөлөл
Ч.Анхтуул - Банкны төлөөлөл
Ө.Сувданшүр - Санхүү албаны дарга
О.Хишигбат - Баялаг бүтээгчдийн холбоо

Нарийн бичгийн дарга: Ц.Урангуа-Мал эмнэлэг үржлийн тасгийн Жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн

2. Сум хөгжүүлэх санг журмын дагуу орон нутагт шаардлагатай төсөлд зарцуулан үр дүнг тооцон ажиллахыг орон тооны бус зөвлөлийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг орон тооны бус хяналтыг зөвлөлд үүрэг болгосугай.

4. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан 2018 оны 01 сарын 18-ны өдрийн 03 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ОТГОНБАЯР

463190005



ӨМНӨГОВЬ АЙМАГ
ГУРВАНТЭС СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

20 19 оны 01 сарын 17 өдөр

Дугаар 04

Урт

Сум хөгжүүлэх сангийн хяналтын зөвлөл
шинэчлэн батлах тухай

Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журмын 3.3.2 дахь заалтыг үндэслэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сум хөгжүүлэх сангийн орон тооны бус хяналтын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Зөвлөлийн дарга Л.Пүрэвдорж- ИТХ-ын тэргүүлэгч

Гишүүдэд: Н.Эрхэмбаяр - Гоёот багийн төлөөлөл
Н.Чинбат - Баясах багийн төлөөлөл
Б.Нарантуяа - Тост багийн төлөөлөл
Н.Энхмандах - Урт багийн төлөөлөл
П.Нямсүрэн - Баялаг бүтээгчдийн холбооны төлөөлөл

Нарийн бичгийн дарга Ж.Ганбаатар–Төсөв төрийн сангийн мэргэжилтэн

2. Сум хөгжүүлэх санг журмын дагуу орон нутагт хэрэгжүүлж байгаа байдалд хяналт тавьж үр дүнг тооцон ажиллахыг орон тооны бус зөвлөлийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдэд даалгасугай.

4. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан 2018 оны 01 сарын 18-ний өдрийн 04 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ХУРЛЫН ДАРГА  Б.ОТГОНБАЯР



463190007



42

ӨМНӨГОВЬ АЙМАГ
ГУРВАНТЭС СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 01 сарын 17 өдөр

Дугаар 05

Урт

Сум хөгжүүлэх сангийн зээлийн дээд
хэмжээг батлах тухай

Монгол улсын Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоол Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журмын 3.3.1 дэх заалтыг үндэслэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. 2019 онд Сум хөгжүүлэх сангаас олгох зээлийн дээд хэмжээг иргэнд 15 сая төгрөг хүртэл, Аж ахуйн нэгжид 25 сая төгрөг хүртэл олгохоор баталсугай.
2. Тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг Сум хөгжүүлэх сангийн зөвлөлд даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг орон тооны бус хяналтын зөвлөлд үүрэг болгосугай.
4. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан 2018 оны 01 сарын 18-ны өдрийн 05 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ОТГОНБАЯР

463190009



43

ӨМНӨГОВЬ АЙМАГ
ГУРВАНТЭС СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 01 сарын 17 өдөр

Дугаар 06

Урт

Амьжиргааг дэмжих зөвлөлийг
шинэчлэн батлах тухай

Монгол улсын Нийгмийн халамжийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3, 27.5 дахь заалтыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сумын Амьжиргааг дэмжих зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй баталсугай.

Зөвлөлийн дарга: Д.Гантулга - Засаг даргын орлогч

Гишүүд: С.Одончимэг – Дотоод ажил, Нийгмийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Э.Алдарбаяр- Нийгмийн даатгалын байцаагч

Н.Дэлгэрмаа - Эрүүл мэндийн төвийн эмч

Ч.Баттогтох - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооны төлөөлөл

Л.Жаалхүү - Ахмадын холбооны төлөөлөл

Нарийн бичгийн дарга: Н.Цэрэннадмид - Хөдөлмөр эрхлэлт халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн

2. Халамжийн тухай хууль, амьжиргааг дэмжих зөвлөлийн дүрмийг хэрэгжүүлж ажлын тайланг бүтэн жилээр Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдэд тайлагнаж ажиллахыг зөвлөлд даалгасугай.

3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 03 сарын 06-ны өдрийн 11 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ОТГОНБАЯР

463190011



44

**ӨМНӨГОВЬ АЙМАГ
ГУРВАНТЭС СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2019 оны 01 сарын 17 өдөр

Дугаар 07

Урт

**Эргэлтийн эмийн сангийн хяналтын
зөвлөл батлах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ийн "г" дахь заалт, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 30 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сумын эргэлтийн эмийн сангийн үйл ажиллагаанд хяналтын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй баталсугай.


Зөвлөлийн дарга О.Баттогтох - Сумын Засаг дарга

Гишүүдэд: Б.Алтанзул – Эрүүл мэндийн төвийн ахлах сувилагч
А.Нямцоо - Иргэдийн төлөөлөл
Л.Хумбага – Засаг даргын тамгын газрын нягтлан бодогч
Б.Цэндсүрэн – Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч
Б.Нарантуяа - Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч

Нарийн бичгийн дарга З.Оюунцэцэг- Эрүүл мэндийн төвийн дарга

2. Эргэлтийн эмийн сангийн үйл ажиллагаанд хяналт тавьж Иргэдийн төлөөлөгчдийн хуралд тайлагнаж ажиллахыг зөвлөлд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ОТГОНБАЯР

463190013



45

ӨМНӨГОВЬ АЙМАГ
ГУРВАНТЭС СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

20 19 оны 01 сарын 17 өдөр

Дугаар 08

Урт

Зөвлөлийн бүрэлдэхүүн батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.1, 22 дугаар зүйлийн 22.1, 22.2 дахь хэсгийг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сумын Залуучуудын хөгжлийг дэмжих зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй баталсугай.

Дарга: О.Баттогтох- Сумын Засаг дарга
Гишүүдэд: Э.Уранбилэг-Ерөнхий боловсролын сургуулийн багш
Б.Батбуян-Гал түймэр унтраах 67-р ангийн захирагч
С.Сугиржав-28 цэцэрлэгийн нярав
Б.Соёлмаа-3 цэцэрлэгийн багш
Э.Сүхээ-Бласт ХХК-ны ажилтан
Э.Төгсбилэг- Хувиараа хөдөлмөр эрхлэгч
Ц.Сумъяа-Хувиараа хөдөлмөр эрхлэгч
С.Шинэсар-Оюутны зөвлөлийн дарга
М.Мэндбаяр-Ар Ди СИ Си ХХК-ны ажилтан
Б.Баярхүү-Саусгоби сэндс ХХК-ны ажилтан
Э.Нямдаваа-Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооны дарга
Э.Сэржмядаг- Хувиараа хөдөлмөр эрхлэгч
Ж.Пунцагбал- Хувиараа хөдөлмөр эрхлэгч
М.Мөнхбархас- Хувиараа хөдөлмөр эрхлэгч
Ц.Мөнхбаатар- Хувиараа хөдөлмөр эрхлэгч

Нарийн бичгийн дарга: С.Одончимэг-Дотоод ажил Нийгмийн асуудал хариуцсан мэргэжилтэн

2. Залуучуудын хөгжлийг дэмжих үйл ажиллагааг орон нутгийн түвшинд зохион байгуулж, чиг үүргийн дагуу үр дүнтэй ажиллахыг зөвлөлд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ОТГОНБАЯР

463190015



46

ӨМНӨГОВЬ АЙМАГ
ГУРВАНТЭС СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

20 19 оны 01 сарын 17 өдөр

Дугаар 09

Урт


Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
шагналаар шагнах тухай

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хөдөлмөрийн дотоод журмын 5 дугаар зүйлийн 5.1 дахь заалтыг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Тус сумын Ерөнхий Боловсролын сургуулийн сурагч Ойдовын Эрхэмбаярын цээж тооллоор улс, дэлхийд гаргасан амжилтыг үнэлж сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Хүндэт өргөмжлөл"-өөр шагнасугай.

2. Дээрх шагналын дагалдах мөнгөн шагнал 100000 /Нэг зуун мянга/ төгрөгийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлаас олгохыг нягтлан бодогч /Н.Цэнгэлмаа /-д зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Б.ОТГОНБАЯР

463190017



ӨМНӨГОВЬ АЙМАГ
ГУРВАНТЭС СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

20 19 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 10

Урт

Ажилчдын цалин шинэчлэн
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэг, 38 дугаар зүйлийн 38.6 дахь хэсэг, Монгол улсын Засгийн газрын 2019 оны 24 тоот тогтоол, Монгол улсын Засгийн газрын 2004 оны 43 тоот тогтоол, Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны 2018 оны 03 сарын 12-ны өдрийн 05 тоот тогтоол, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 94 тоот тогтоолыг тус тус үндэслэн Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажилчдын цалинг нэгдүгээр, Багийн Иргэдийн Нийтийн Хурлын дарга нарт сар бүр олгох урамшууллыг хоёрдугаар, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд улиралд олгох урамшууллыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Уг тогтоолд заагдсан ажилчдын Үндсэн цалин, нэмэгдэл урамшууллыг тухай бүр тооцож олгохыг Нягтлан бодогч /Н.Цэнгэлмаа/-д үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 02 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ОТГОНБАЯР

463190019



Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн
2019 оны 10 тоот тогтоолын нэгдүгээр хавсралт

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын орон тоо, цалингийн сан

№	Албан тушаал	Цалингийн шатлал	Үндсэн цалин	Ажилласан жил			Нэмэгдлүүд					Дүн		
				Улсад	Төрийн байгууллагад	Тухайн албан тушаалд	Онцгой нэмэгдэл /%/	ТАХ-ны /%/	Зөвгөдөв /%/	ХАСХОМ /%/	Үр чадвар			
1	ИТХ-ын дарга	УТ	974266	15	15	3	/30/						1266545,8	
2	ИТХТ-ийн нарийн бичгийн дарга	ТЗ-7-5	855978	14	14	14		/10/	85597,8	/22/	188315,16	/10/	85597,8	1215488,76
3	ИТХ-ын жолооч, ажилтан	ТҮ-3-1	468980	-	-	-	-	-	-	-	-	-	-	609674




Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн
2019 оны... тоот тогтоолын хоёрдугаар хавсралт

Багийн Иргэдийн Нийтийн хурлын дарга нарын урамшуулал

№	БИНХ-ын дарга	Олгох урамшуулал /сар бүр/	Тайлбар
1	Гоёот багийн ИНХ-ын дарга	193719	ЗЗНДНТУТХ-ийн 38 дугаар зүйлийн 38.6 дахь хэсэгт зааснаар
2	Баясах багийн ИНХ-ын дарга	193719	
3	Тост багийн ИНХ-ын дарга	193719	
4	Урт багийн ИНХ-ын дарга	193719	
5	Бага-Овоо багийн ИНХ-ын дарга	193719	
ДҮН		968595	

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн
2019 оны 10 тоот тогтоолын гуравдугаар хавсралт



57

ИТХТэргүүлэгчдийн урамшуулал

№	БИНХ-ын дарга	Олгох урамшуулал /Улиралд нэг удаа/	Тайлбар
1	О.Батмөнх	192000	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010.08.20-ны өдрийн 94 тоот тогтоолоор
2	Г.Гангамаа	192000	
3	Ц.Манлайбаатар	192000	
4	Ж.Мөнхбаяр	192000	
5	Л.Пүрэвдорж	192000	
6	Н.Эрхэмбаяр	192000	
	ДҮН	1152000	



ӨМНӨГОВЬ АЙМАГ
ГУРВАНТЭС СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

20 19 оны 02 сарын 19 өдөр

Дугаар 11

Урт

“Дархан бэр” энгэрийн тэмдэг,
үнэмлэх олгох журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх хэсгийг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Гурвантэс сумын “Дархан бэр” энгэрийн тэмдэг, үнэмлэх олгох журмыг нэгдүгээр, Дархан бэр шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Уг тогтоолыг хэрэгжүүлж, олон нийтэд сурталчилж ажиллахыг сумын “Дархан бэр” шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ОТГОНБАЯР

463190021

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2019 оны 11 тоот тогтоолын
нэгдүгээр хавсралт



ГУРВАНТЭС СУМЫН “ДАРХАН БЭР” ЭНГЭРИЙН ТЭМДЭГ, ҮНЭМЛЭХ ОЛГОХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Монголын ард түмний эрт дээр үеэс уламжлан ирсэн ёс заншлыг олон нийтэд сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх, гэр бүлийн соёл, хүмүүжил уламжлалыг дээдлэн хөгжүүлэх, бэр болж очсон айлдаа гурван хүү дараалан төрүүлж, тухайн айлын гал голомт, удам угсааг залгамжлах хөвгүүдийг өсгөн хүмүүжүүлсэн эмэгтэйг хүндэтгэн “ДАРХАН БЭР” хэмээн өргөмжилж, Гурвантэс сумын нэрэмжит шагнал болох “Дархан бэр” энгэрийн тэмдэг, үнэмлэх олгохтой холбоотой харилцааг зохицуулахад оршино.

ХОЁР. “ДАРХАН БЭР” ШАГНАЛД ТОДОРХОЙЛОХ, ШАГНАХ АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ

2.1. “Дархан бэр” шагналд тодорхойлоход дараах материалыг бүрдүүлж Гурвантэс сумын Засаг даргын Тамгын газрын Нийгмийн ажилтанд тухайн жилийн 3 сарын 01-ний дотор ирүүлнэ. Үүнд:

- а/ Дараалан гурван хүү төрүүлсэн эхийн иргэний үнэмлэхний хуулбар
- б/ Хүүхдүүдийн төрсний гэрчилгээний хуулбар
- в/ Харъяа багийн Засаг даргын тодорхойлолт

2.2. Засаг даргын Тамгын газрын Нийгмийн ажилтан нь ирүүлсэн бичиг, баримтыг “Дархан бэр” шалгаруулах ажлын хэсэгт танилцуулж, ажлын хэсэг нь ирүүлсэн материалыг нягтлан шалгаж сумын “Дархан бэр”-ээр өргөмжлөх асуудлыг шийдвэрлэнэ.

2.3. Сумын “Дархан бэр”-ээр өргөмжилж, алдаршуулах ажлыг сумын ИТХ, ЗДТГ-аас жилд нэг удаа ёслол төгөлдөр зохион байгуулна.

2.4. Сумын “Дархан бэр”-ээр өргөмжлөгдөж буй ээжүүдэд энгэрийн тэмдэг, үнэмлэх олгоно.

ГУРАВ. ХАМРАХ ХҮРЭЭ, БОЛЗОЛ ШААРДЛАГА

3.1. Энэхүү журам нь Гурвантэс суманд харъяалалтай эхчүүдэд хамаарна.

3.2. Тухайн эхийн төрүүлж өсгөсөн хүүхдүүд хамаарах ба бусдаас үрчилж авсан хүүхэд хамаарахгүй

3.3. Бэр болж очсон айлдаа дараалан 3 хүү төрүүлж өсгөн, хүүхдүүд /хүү/ нь овог нэгтэй байх бөгөөд бага хүү нь нэг нас хүрсэн байх.

ДӨРӨВ. ХЭРЭГЖИЖ ЭХЛЭХ ХУГАЦАА

Энэхүү журмыг 2019 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

___оОо___

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2019 оны ... тоот тогтоолын
хоёрдугаар хавсралт



95

**“ДАРХАН БЭР” ШАЛГАРУУЛАХ АЖЛЫН
ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

- Ажлын хэсгийн дарга: Сумын Засаг даргын орлогч
Гишүүдэд: Гоёт багийн Засаг дарга
Баясах багийн Засаг дарга
Тост багийн Засаг дарга
Урт багийн Засаг дарга
Бага-Овоо багийн Засаг дарга
Улсын бүртгэгч
Хөдөлмөр, халамж үйлчилгээний мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга: ЗДТГ-ын Дотоод ажил, Нийгмийн асуудал хариуцсан мэргэжилтэн

_____оОо_____



46

**ӨМНӨГОВЬ АЙМАГ
ГУРВАНТЭС СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

20 19 оны 02 сарын 19 өдөр

Дугаар 12

Урт

Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах
иргэдийг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1 дахь хэсгийг тус тус үндэслэн сумын Засаг даргын Тамгын газрын дарга Ц.Дэлгэрмаагийн саналыг хэлэлцээд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Тус сумаас 2019-2021 онд Цэргийн албыг дүйцүүлэн хаах иргэдийн нэрсийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Энэ тогтоолыг холбогдох материалын хамт аймгийн Засаг даргад хүргүүлэхийг сумын Засаг дарга /О.Баттогтох/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ОТГОНБАЯР

463190023

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2019 оны 12 тоот тогтоолын
хавсралт



ГУРВАНТЭС СУМААС 2019-2021 ОНД ЦЭРГИЙН
АЛБЫГ БИЕЭР ДҮЙЦҮҮЛЭН ХААР ИРГЭД:

№	Овог нэр	Регистрийн дугаар	Ам бүлийн тоо	Багийн харъяалал
1	Учралын Энхбаатар	КГ99100118	6	Гоёот
2	Эрдэнээгийн Сайнхүү	КГ00271113	5	Тост



ӨМНӨГОВЬ АЙМАГ
ГУРВАНТЭС СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

20 19 оны 02 сарын 19 өдөр

Дугаар 13

Урт

Төрийн дээд шагналд
тодорхойлох тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.15 дахь заалтыг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Тус сумын Гоёот багийн малчин, өндөр настан Цэрэндуламын Пүрэвийг “Хөдөлмөрийн хүндэт” медалиар шагнуулах саналыг дэмжсүгэй.

2. Шагнуулахаар тодорхойлсон материалыг холбогдох дээд байгууллагад уламжлахыг сумын Засаг дарга /О.Баттогтох/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ОТГОНБАЯР

463190027



97

**ӨМНӨГОВЬ АЙМАГ
ГУРВАНТЭС СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2019 оны 04 сарын 05 өдөр

Дугаар 14

Урт

“Алдарт эх” одонгоор шагнагдах
эхчүүдийн нэрийг батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дахь заалтыг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Алдарт эх” нэг, хоёрдугаар зэргийн одонгоор шагнагдах эхчүүдийн нэрийг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тогтоолыг холбогдох материалын хамт Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын ажлын албанд хүргүүлэхийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /П.Одончимэг/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ОТГОНБАЯР

463190029



Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2019 оны 04 сарын 05-ны өдрийн
14 тоот тогтоолын хавсралт

АЛДАРТ ЭХ ОДОНГООР ШАГНАГДАХ ЭХЧҮҮДИЙН НЭРС

№	Эхийн овог нэр	Регистрийн дугаар	Багийн харъяалал
“Алдарт эх” нэгдүгээр одонгоор:			
1	Жаалхүүгийн Туяа	КГ79021508	Гоёт баг
“Алдарт эх” хоёрдугаар одонгоор:			
1	Дашравдангийн Баяржаргал	ВР86040509	Гоёт баг
2	Доржбатын Болормаа	ВВ91011203	Гоёт баг
3	Төмөрбаатарын Мягмарханд	КГ88112903	Гоёт баг
4	Сүрэнжавын Наранчимэг	КГ84101507	Гоёт баг
5	Батбаярын Мядагмаа	КИ90081003	Баясах баг
6	Содномын Отгонсүвд	КГ87061403	Баясах баг
7	Хүүхэнхүүгийн Цагаанцэцэг	КГ82091009	Баясах баг
8	Самбын Буянхишиг	КГ86011606	Тост баг
9	Баттөмөрийн Есүүжин	ИЦ88022004	Тост баг
10	Жаалхүүгийн Одгэрэл	КЮ82081201	Тост баг
11	Самбасүрэнгийн Цэвэгмэд	КГ92092508	Тост баг
12	Эрдэнийн Цэнгэлмаа	КИ85021567	Тост баг
13	Бадарчийн Алтанзул	КГ87042709	Урт баг
14	Сайнбуянгийн Жавзандолгор	КГ85021500	Урт баг
15	Ганбаатарын Ууганцэцэг	КЛ80071807	Урт баг



142

ӨМНӨГОВЬ АЙМАГ
ГУРВАНТЭС СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

20 19 оны 04 сарын 16 өдөр

Дугаар 15


Урт

Төрийн дээд шагналд тодорхойлох тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.15 дахь заалтыг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Тус сумын Урт багийн иргэн ахмад настан Аюушийн Нямцоог “**Алтан гадас**” одонгоор шагнуулах саналыг дэмжсүгэй.
2. Шагнуулахаар тодорхойлсон материалыг холбогдох дээд байгууллагад уламжлахыг сумын Засаг дарга /О.Баттогтох/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ОТГОНБАЯР

463190033



147

**ӨМНӨГОВЬ АЙМАГ
ГУРВАНТЭС СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2019 оны 04 сарын 16 өдөр

Дугаар 16

Урт

Зөвлөлийн бүрэлдэхүүн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 30 дугаар тогтоолыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Тогтвортой хөгжил-түншлэл” хамтын ажиллагааны салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй баталсугай.

Зөвлөлийн дарга- Б.Отгонбаяр-сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга

Гишүүд: - О.Батмөнх- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хөдөө аж ахуй, аялал жуулчлал, байгаль орчны хорооны дарга

- Д.Гантулга- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нийгмийн бодлого, хууль эрх зүйн хорооны гишүүн
- Ц.Манлайбаатар- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Уул уурхай, дэд бүтцийн хорооны дарга
- Ц.Дэлгэрмаа- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын эдийн засаг, өмч, төсөв санхүүгийн хорооны дарга
- Б.Энхжаргал- Ерөнхий Боловсролын Сургуулийн захирал
- Б.Алтантуяа- 28 дугаар цэцэрлэгийн эрхлэгч
- З.Оюунцэцэг- Эрүүл мэндийн төвийн эрхлэгч
- Э.Золбообаяр- “Шугшаа-Уул” Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга
- Ц.Батмөнх- Төрийн банкны эрхлэгч
- П.Нямсүрэн- үйлдвэрлэгч

2. Аймаг, сумын хэмжээнд хэрэгжиж буй урт болон дунд хугацааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллахыг зөвлөлд үүрэг болгосугай.

3. Зөвлөлийг ажиллах боломж, нөхцөлөөр ханган шаардлагатай дэмжлэг үзүүлж ажиллахыг сумын Засаг дарга /О.Баттогтох/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ОТГОНБАЯР

453100036



148

ӨМНӨГОВЬ АЙМАГ
ГУРВАНТЭС СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

20 19 оны 04 сарын 16 өдөр

Дугаар 17

Урт

Зөвлөлийн бүрэлдэхүүн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 44 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Шинэ баг төсөл”-ийг суманд хэрэгжүүлэх салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй баталсугай.

Зөвлөлийн дарга - сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга

Гишүүд:

- Сумын Засаг даргын орлогч
- Гоёот багийн Засаг дарга
- Баясах багийн Засаг дарга
- Тост багийн Засаг дарга
- Урт багийн Засаг дарга
- Бага-Овоо багийн Засаг дарга
- Газрын харилцаа, Барилга хот байгуулалт хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичиг- Засаг Даргын Тамгын Газрын нийгмийн ажилтан

2. Сумын хэмжээнд “Шинэ баг төсөл”-ийг хэрэгжүүлэхэд удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг зөвлөлд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ОТГОНБАЯР

463199937



ӨМНӨГОВЬ АЙМАГ
ГУРВАНТЭС СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 18

Урт

Хяналтын зөвлөл шинэчлэн батлах тухай

Сангийн сайдын 2018 оны 09 сарын 12-ны өдрийн 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэгт заасныг үндэслэн Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх хөрөнгө оруулалтуудад хяналт үнэлгээ хийх Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх Хяналтын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй баталсугай. Үүнд:

Зөвлөлийн даргад: Н.Энхмандах- Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч

Гишүүдэд: Б.Нарантуяа - Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч

Ц.Ганбаатар - Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч

Ж.Мөнхбаяр - Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч

Н.Галаахүү - Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч

2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын хэрэгжилтийн явцад байнгын хяналт тавьж, тайланг жилийн эцэст Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдэд танилцуулж ажиллахыг хяналтын зөвлөлийн дарга/ Н.Энхмандах/-д үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 03 сарын 06-ны өдрийн 12 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ОТГОНБАЯР

463190039



147

ӨМНӨГОВЬ АЙМАГ
ГУРВАНТЭС СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

20 19 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 19

Урт

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсгийг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Гурвантэс сумын нутаг дэвсгэрт гэрийн тэжээвэр нохойг тэжээх гэрчилгээжүүлэх, пайзжуулах, журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Уг тогтоолыг хэрэгжүүлж, нийт иргэд байгуулага, аж ахуй нэгжид сурталчлан хүргэж, мөрдүүлэх ажлыг зохион байгуулахыг сум, багийн Засаг дарга, Мал эмнэлгийн тасагт тус тус даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА




Б.ОТГОНБАЯР

463190041

178

Гурвантэс сумын Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 06 сарын 10-ны
өдрийн 19 тоот тогтоолын хавсралт



**ГЭРИЙН ТЭЖЭЭВЭР НОХОЙГ ТЭЖЭЭХ
ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭХ, ПАЙЗЖУУЛАХ ЖУРАМ**

Нэг. Зорилго

Гэрийн тэжээвэр нохойг бүртгэл судалгаанд хамруулж мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулан “Мал амьтны эрүүл мэндийг хамгаалах тухай” хуулийг орон нутагт хэрэгжүүлэн ажиллаж хүн амын эрүүл аюулгүй орчин амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлэхэд энэхүү журмын зорилго оршино.

Хоёр. Үндэслэл

Гурвантэс сумын нутаг дэвсгэрт тэжээвэр болон золбин нохой ихэссэнээс байгаль орчин бохирдуулах хараа хяналтгүй, уяагүй нохой хүн, мал хазах, ураг тохиолдол олширч тарилга туулгалтанд хамрагдаагүйн улмаас халдварт өвчин тараах нөхцөл байдал үүсэж байгаа учир журам боловсруулах мөрдөн ажиллах шаардлагатай болсон.

Бүртгэл судалгаанд хамрагдаагүйн улмаас иргэд эм нохой өсгөн үр төлийг төвлөрсөн газар аваачиж тавин золбин нохойны тоо олширч малчдын мал сүрэгт халдаж олноор нь барьж малчдад эдийн засгийн ихээхэн хохирол учруулж байгаа төдийгүй хүн хазаж эрүүл мэндийг нь хохироох асуудал олон удаа гарч байна. Хэдийгээр нохойнд устгал хийж байгаа боловч үр дүнгүй хөрөнгө мөнгө их зарцуулж ямарч ач холбогдолгүй болж байгаа учир цэгцэлж мал эмнэлгийн арга хэмжээг нэгдсэн байдлаар зохион байгуулах шаардлага бидний өмнө тулгараад байна.

Гурав. Гэрийн тэжээвэр амьтан тэжээх ашиглагчийн эрх үүрэг

3.1 Гэрийн тэжээвэр нохой тэжээх иргэн, өрх, аж ахуйн нэгж байгууллага тухайн багийн Засаг даргад бүртгүүлэн мал эмнэлгийн тасгаас гэрчилгээ авсан байна.

3.2 Өөрийн нохойтой холбогдон гарсан хог хаягдал, ялгадасыг байнга цэвэрлэж, орчныг бохирдуулахгүй, нийтийн амгалан тайван байдлыг хангана.

3.3 Тэжээвэр нохойг шөнийн 00 цагаас өглөөний 06 цаг хүртэл сул байлгах ба өдрийн бусад цагт тусгай зориулалтын уяанд уяна.

3.4 Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн ариутгал, халдваргүйжүүлэлтийн үйлчилгээг /галзуугийн эсрэг вакцин, улирал бүр туулгалт/ мэргэжлийн байгууллагаар жил бүр хийлгэж, гэрчилгээнд тэмдэглэл хийлгэнэ.

3.5 Тэжээвэр нохойг нийтийн эзэмшлийн гудамж талбайд авч явахдаа нохойн зан авираас үл хамааран зориулалтын хошуувч, оосор ашиглана.

3.6 Эм нохой тэжээсэн тохиолдолд төрүүлэхгүй байх арга хэмжээг шинжлэх ухааны болон уламжлалт аргыг ашиглах арга хэмжээг авч мал эмнэлгийн үйлчилгээний нэгжтэй хамтран ажиллах.

3.7 Нохой тэжээгчийн хариуцлагагүй үйлдлээс болж нохой нь бусдад хохирол учруулсан тохиолдолд хохирлыг нохойны эзэн бүрэн хариуцна.

3.8 Иргэн өөрийн буруутай, хариуцлагагүй үйлдлээс болж нохойтой холбоотой хохирол амсвал тухайн нохой тэжээгч хариуцлага хүлээхгүй.

3.9 Нохой тэжээх, худалдаж авах, бэлгэнд авснаас хойш нэг сарын дотор багийн Засаг даргад бүртгүүлж, харъяа мал эмнэлгийн тасаг эсвэл нэгжээс гэрчилгээ пайз авна.

3.10 Нохой тэжээж буй гэр хорооллын айл өрхүүд хашааны хаалганы гадна талд өдөр шөнийн цагаар бусдад харагдахуйц ил тод анхааруулах "Нохойтой" гэсэн тэмдэг тэмдэглэгээ хийсэн байна.

3.11 Нохой тэжээгч нь эрх бүхий байгууллагаас тогтоосон татвар хураамжийг хуулийн хугацаанд төлөх

Дөрөв. Мал эмнэлгийн байгууллагын эрх, үүрэг

4.1 Мал эмнэлгийн тасаг, Мал эмнэлэг үйлчилгээний нэгж нь нохойны гэрчилгээг олгож пайзжуулах ажлыг хийж гүйцэтгэнэ.

4.2 Мал эмнэлгийн байгууллага нь "Мал, амьтны эрүүл мэндийн тухай" хуулийг мөрдөж ажиллах, малчдад мөрдүүлэх үүрэгтэй.

4.3 Мал эмнэлгийн гэрчилгээ бичиж олгох, хяналт тавих, нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх, заавар зөвлөмж өгөх үүрэгтэй.

4.4 Мал эмнэлгийн өдөр тутмын үйлчилгээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээг гэрчилгээнд тогтмол хөтлүүлж хэвшүүлэх

4.5 Иргэдийг мэдээлэлээр хангаж, ирсэн дуудлага болгонд цаг алдалгүй явж иргэдэд үйлчилгээ үзүүлэх

Тав. Хориглох зүйл

5.1 Нохойг хамгаалалтгүй байлгаснаас хүн, мал уруулах, эмчилгээ шинжилгээ хийлгэлгүй тэжээх, золбируулж хаяхыг хориглоно.

5.2 Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн тарилга шинжилгээнд хамрагдаагүй гэрчилгээгүй нохой тэжээх, нуун дарагдуулахыг хориглоно.

5.3 Тэжээвэр нохойг гудамжинд сул чөлөөтэй явуулахыг хориглоно.

5.4 Нохой тэжээгч нь өөрийн эзэмшилд бүртгэлгүй нохой, тэжээхийг хориглоно.

Зургаа. Тэжээвэр нохойны тооллого

6.1 Тэжээвэр нохойны бүртгэл судалгааг Сумын Засаг даргын тамгын газар, Мал

эмнэлгийн тасаг, Мал эмнэлэг үйлчилгээний нэгж, Багийн Засаг дарга хөтөлж жил бүрийн мал тооллогын үеэр нохойн тооллогыг хамтатган явуулна.

Долоо. Журмын биелэлтэнд хяналт тавих

7.1 Энэхүү журмын биелэлтэнд Гурвантэс сумын Засаг даргын тамгын газар, Багийн Засаг дарга нар, Мал эмнэлгийн тасаг, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж эрх бүхий улсын байцаагч нар хяналт тавьж ажиллана.

Найм. Санхүүжилт

- 8.1 Нохойн татвар хураамж
- 8.2 Орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө
- 8.3 Хандив, тусламж

Ес. Хариуцлага

9.1 Нохой эзэмшигч нь тогтоосон хугацаанд галзуу, туулгалт болон мал амьтны өвчлөлөөс урьдчилан сэргийлэх тарилга, туулгалт хийлгээгүй тохиолдолд Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн дагуу эзэнд нь арга хэмжээ тооцно.

9.2 Энэхүү журмын заалт болон мэргэжлийн холбогдох байгууллагын тавьсан шаардлагын удаа дараа биелүүлээгүй иргэн, аж ахуй нэгж, байгууллагад тухайн шатны Засаг дарга, улсын байцаагч нар хуульд заасан бүрэн эрхийнхээ дагуу арга хэмжээ авна.

_____оОо_____



181

**ӨМНӨГОВЬ АЙМАГ
ГУРВАНТЭС СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

20 19 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 20

Урт

Орон нутгийн тусгай хэрэгцээний
газраас зарим газар нутгийг чөлөөлөх тухай


Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ийн “з”, 20 дугаар зүйлийн 20.1 дэх заалтыг тус тус үндэслэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2015 оны 12 сарын 11-ны өдрийн 13/09 тоот тогтоолоор орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан “Ихэр шовон” нэртэй талбайгаас 117,57 га, 2017 оны 07 сарын 05-ны өдрийн 4/06 тоот тогтоолоор орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан “Гүн” нэртэй талбайгаас 230,41 га талбай, нийт 347,98 га газрыг орон нутгийн тусгай хэрэгцээний газраас чөлөөлж, солбицолыг нэгдүгээр, зургийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Тогтоолыг Ашигт малтмалын газрын кадастрын хэлтэст уламжилж кадастрын зураг зүйн мэдээллийн санд бүртгүүлэхийг сумын Засаг дарга /О.Баттогтох/-д үүрэг болгосугай.

3. Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдаанд уг тогтоолыг танилцуулахыг сумын Хурлын дарга /Б.Отгонбаяр/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ОТГОНБАЯР

182

Гурвантэс сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2019 оны 06 сарын 10-ны
өдрийн 10 тоот тогтоолын нэгдүгээр хавсралт



Орон нутгийн тусгай хэрэгцээний газраас гаргаж


буй талбайн солбицол

/347.96 га/


№	Уртраг			Өгрөгөр		
	101	9	58.97	43	11	22.79
1	101	9	58.97	43	11	22.79
2	101	9	56.35	43	12	1.75
3	101	10	42.03	43	12	1.49
4	101	11	59.64	43	12	9.54
5	101	11	58.52	43	11	23.09

183

Гурвантэс сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2019 оны 06 сарын 10-ны
өдрийн тоот тогтоолын хоёрдугаар хавсралт



Орон нутгийн тусгай хэрэгцээний газраас гаргаж буй талбайн зураг



Ихэр шовон

Талбайн хэмжээ
347.96 га

Гүн